Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
ЭМДЕГ-ын Ёс зүйн дэд хороо нь ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/164, 2025 оны А/94 дүгээр тушаалаар орон нутгийн төлөөлөл бүхий 3 гишүүн, төв аппаратын төлөөлөл 4, нийт 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Ёс зүйн хороо"-ны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх чиг үүргийн хүрээнд 2025 онд ёс зүйн дэд хорооны даргын баталсан 11 заалт бүхий ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 онд тус дэд хороонд 3 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч, бүртгэн, ёс зүйн дэд хорооны гишүүдэд хуваарилж, ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэн, гомдлыг шийдвэрлэн ажилласан. Тухайн гомдол мэдээлэл, шийдвэрлэлтийн байдлыг "Ёс зүйн хороо"-ны цахим бүртгэлд тухай бүр бүртгэж, тайланг хүргүүлсэн. Үүнд: 025.02.24-ний өдөр ЭМДЕГ-ын албан тушаалтнаас албан тушаалтанд холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч, Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 8.1.3 дахь хэсэгт заасан ёсзүйн зөрчил гаргасан гэж дүгнэн, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, ёсзүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд бүртгэсэн. 025.08.26-ны өдөр 1111 төвөөр дамжуулан иргэнээс ЭМДЕГ-ын албан тушаалтанд холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч, Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсгийг зөрчсөн гэж дүгнэн, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, сахилгын ёсзүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд бүртгэж шийдвэрлэсэн. 025.11.27-ны өдөр Өвөрхангай аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн албан тушаалтанд холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч, Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэг, 7.1.7 дахь хэсгийг зөрчсөн гэж дүгнэн, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, сахилгын ёсзүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд бүртгэж шийдвэрлэсэн.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний х
2.1.1. Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг бууруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчилд өртөх эрсдэл өндөр албан тушаал эрхэлдэг албан хаагчийг ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг тооцох үнэлгээг гаргах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2.1.2. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн албан хаагчийг ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг танилцуулах сургалтын хөтөлбөрийг гарган баталж 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн ЭМДЕГ-ын "Мэдээллийн цаг"-аар тус сургалтыг зохион байгуулсан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2.1.3. Байгууллагын хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн холбогдолтой хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, ёс зүйн зарчим, хэм хэмжээ шаардлагуудыг биелүүлж, аливаа зөрчилгүй ажиллах соёлыг нэвтрүүлэхээр зурагт хуудас, мэдээллийг бэлтгэн ЭМДЕГ-ын цахим хуудсаар дамжуулан түгээн ажилласан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Томилох эрх бүхий албан тушаалтан нь Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжин манлайлж, сургалт явуулах боломжоор хангах, дэд хорооны гишүүдийг сургалтанд хамруулах, дэд хорооноос гаргасан дүгнэлтийг хүлээн авч хуульд нийцсэн шийдвэрийг зэргээр дэмжин ажиллаж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
2.3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой “зурагт хуудас” бэлтгэж, “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” фэйсбүүк хуудсанд байршуулсан. 2.3.2.ЭМДЕГ-ын “Ёс зүйн дэд хорооны хурлын дэг”-ийг боловсруулж, гишүүдээс санал авч, батлуулан дэгийг мөрдөн ажиллаж байна. 2.3.3.“Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ёс зүйн дэд хорооны дүгнэлт”-ийн хэвлэмэл хуудасны загварыг гарган батлуулж, үйл ажиллагаандаа хэрэглэж эхлээд байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1.Онлайн хурлыг амжилттай зохион байгуулж, гомдол гаргагч болон холбогдогчийг хуралд саадгүй оролцох боломжийг хангасан.	1. Дэд хорооны гишүүдийг сургалтад бүрэн хамруулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах асуудал нь тулгамдсан асуудал байна.

Санал:
аашид Ёс зүйн хорооноос сургалтын дэмжлэг авах; с зүйн дэд хорооны гишүүдийг сургалтад хамруулах;

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/ */Гарын үсэг/* *(А. Удвал үзүүт)* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 30.

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	
Хэсгийн оноо				**4**	**2,5**	2,5
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	
Хэсгийн оноо				**3**	**1**	1
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	
Хэсгийн оноо				**3**	**2**	2
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**5,5**	**55**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур
[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох
[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн

-oOo-

БАТЛАВ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
С.СУВД-ЭРДЭНЭ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах албан хаагч
I. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр						
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Хамрагдсан албан хаагдчын тоо	Байгуулагын нийт албан хаагчид	III	ЭМДЕГ-ын нийт албан хаагчид	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2	"Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг танилцуулах сургалт	Хамрагдсан албан хаагдчын тоо	Байгуулагын нийт албан хаагчид	IV	ЭМДЕГ-ын нийт албан хаагчид	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
3	Үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл эрсдлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Арга хэмжээ, албан хаагчдын тоо	Албан хаагчид холбогдох хууль, журмын талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.	Жилд 2-оос доошгүй удаа	ЭМДЕГ-ын нийт албан хаагчид	Ёс зүйн дэд хорооны дарга гишүүд
4	Шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх сургалтын хүний нөөц,	Арга хэмжээ, албан хаагчдын тоо	Шинэ албан хаагчид холбогдох хууль, журмын талаар мэдлэг	Жилд 2-оос доошгүй удаа	Шинээр ажилд орсон албан хаагчид	Ёс зүйн дэд хорооны дарга гишүүд

	сургалт хариуцсан албан хаагчтай хамтран сургалтыг зохион байгуулах		мэдээлэлтэй болсон байна.			
II. Зөрчил хянан шийдвэрлэх						
5	Иргэд, байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох	Шалтгаан нөхцлийг тогтоосон байдал	Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийн дагуу арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.	Хагас, бүтэн жил	Иргэд	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
6	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэж, дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.	Шийдвэрлэсэн гомдлын тоо	Ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж, хариуцлага тооцно.	Бүтэн жилийн турш	ЭМДЕГ-ын албан хаагчид, хорооны гишүүд	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах	Шийдвэрлэсэн гомдлын тоо	Өргөдөл гомдол хууль журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Тухай бүр	ЭМДЕГ-ын нийт албан хаагчид	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
III. Ёс зүйн дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр						
8	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны, сургалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах	Төлөвлөгөө батлагдсан байх	Төлөвлөгөө батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.	I сард	Ёс зүйн дэд хороо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
9	Ёс зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт	Журам шинэчилсэн байдал	Үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.	Жилд 1-ээс доошгүй	Ёс зүйн дэд хорооны гишүүд	Ёс зүйн дэд хорооны дарга
IV. Үйл ажиллагааг тайлагнах мэдээлэх						

10	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан мэдээг гаргаж, ёс зүйн хороонд хүргэх	Тайлан хүргүүлсэн тоо	Тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.	Улирал бүр	Ёс зүйн дэд хороо	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
11	Албан хаагчдын дунд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил түүний шалтгаан, эрсдлийн талаар байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх	Зөвлөмж хүргүүлсэн эсэх	Албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн байна.	Жилд 1-ээс доошгүй	Ёс зүйн дэд хороо	Ёс зүйн дэд хорооны дарга